



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2017 оны 12 сарын 28 өдөр

Дугаар A/547

Улаанбаатар хот

Г  
Г  
Элэгний хорт хавдрыг эрт илрүүлэх үзлэг  
зохион байгуулах журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтыг үндэслэн Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.3 дахь зорилт, “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2017 оны 112 дугаар тогтоолын хавсралтын 3.2.1.7 дахь заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор ТУШААХ нь:

1. Элэгний хорт хавдрыг эрт илрүүлэх үзлэг зохион байгуулах журмыг нэгдүгээр, эрт илрүүлэг үзлэг, оношилгоо, эмчилгээний алгоритмыг хоёрдугаар, илрүүлгийг бүртгэх, мэдээлэх журмыг гуравдугаар, эрт илрүүлгийн сарын мэдээний нэгтгэлийн маягт, үзлэг, мэдээллийн урсгалын загварыг дөрөвдүгээр, хорт хавдрын илрүүлэг, үзлэгийг мэдээлэх хуудсыг тавдугаар, элэгний хатуурлын хүндрэлийн зэргийг тодорхойлох Чайлд-Пью шалгуурыг ашиглах зааврыг зургаадугаар, шаардагдах тоног, төхөөрөмжийн жагсаалтыг долоодугаар, шалгуур үзүүлэлтийг наймдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт даалгах нь:

а/ энэхүү тушаалын хэрэгжилтийг хангах, зорилтот бүлгийн хүн амын хамралтыг сайжруулах, байгууллагуудын үйл ажиллагааны уялдааг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авах;

б/ элэгний хорт хавдрын эрт илрүүлэг, үзлэгийн үйл ажиллагааны цогц төлөвлөгөө, шалгуур үзүүлэлт батлан мөрдүүлэх;

в/ эрт илрүүлгийн үзлэг, шинжилгээнд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж, багаж, тоног төхөөрөмж, үйл ажиллагаанд шаардагдах зардлыг жил бүрийн орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж байх;

г/ мэдээ тайланг үнэн зөв гарган цаг хугацаанд нь ирүүлэх;

д/ хэрэгжилтэд тогтмол хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тулгамдсан асуудал, шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж, багаж, тоног төхөөрөмжийн хэрэгцээ, үзлэгийн тайлан мэдээг хагас жил тутам Хавдар судлалын үндэсний төвд мэдээлж байх;

е/ хүний нөөцийг зөв байршуулах, давтан сургах, бэлтгэгдсэн хүний нөөцийг тогтвортой ажиллуулах;

ж/ ажлын үр дүнгээр урамшуулж байх;

3. Элэгний хорт хавдрын эрт илрүүлгийг улсын хэмжээнд зохион байгуулж, бүртгэл, мэдээлэл, холбогдох байгууллагуудыг мэргэжил арга зүйгээр хангаж, эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж, багаж, тоног төхөөрөмжийн хангалт, элэг шилжүүлэн суулгах эмчилгээнд шаардагдах хөрөнгийн тооцооллыг хийж жил бүрийн улсын төсөвт суулгуулах арга хэмжээ авч байхыг Хавдар судлалын үндэсний төв (Ж.Чинбүрэн)-д, илрүүлэг үзлэгийг сурталчилж, зорилтот бүлгийн хүн амыг бүрэн хамруулах зохицуулалтаар хангаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (Б.Цогтбаатар)-д, эрт илрүүлэгт шаардлагатай хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах тасралтгүй сургалтыг хамтран зохион байгуулж байхыг Хавдар судлалын үндэсний төв (Ж.Чинбүрэн), Эрүүл мэндийн хөгжлийн төвд тус тус үүрэг болгосуай.

4. Элэгний хорт хавдрын эрт илрүүлэгт шаардагдах эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж, багаж, тоног төхөөрөмжийн хангалтын тооцооллыг үндэслэн шаардагдах зардлыг жил бүрийн улс, орон нутгийн төсөвт тусгаж байхыг Эм, үйлдвэрлэл, технологийн газар /Л.Мөнхтүлга/, Эдийн засаг, санхүүгийн хэлтэс (Б.Пүрэвсүрэн)-т, нэгдсэн зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн газар(Д.Ганцэцэг)-т, сум, өрхийн эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн бэлэн байдал, үйл ажиллагааны уялдааг хангаж ажиллахыг Эмнэлгийн тусlamжийн газар (Я.Буянжаргал)-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Б.Баярт)-т тус тус даалгасугай.

САЙД

Д.САРАНГЭРЭЛ



Эрүүл мэндийн сайдын  
2017 оны 12 сарын 28-ны өдрийн  
A/547 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

## Элэгний хорт хавдрын эрт илрүүлэх үзлэг зохион байгуулах журам

### Нэг. Нийтлэг үндэслэл:

1.1. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.3 дахь зорилтыг хэрэгжилтийг хангах “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн хүрээнд 2020 он гэхэд элэгний хорт хавдар, хатуурлаас шалтгаалсан нас барагтыг эрс бууруулах зорилгоор элэгний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулж, эрт илрүүлгийн тогтолцоог бүрдүүлэх зорилготой.

1.2. Хүн амд суурилсан эрт илрүүлэг үзлэгийг бүх шатлалын эрүүл мэндийн байгууллагыг түшиглэн бусад хөтөлбөр, арга хэмжээтэй уялдуулан зохион байгуулна.

### Хоёр: Эрт илрүүлэг, үзлэгийн зохион байгуулалт:

2.1. Элэгний хорт хавдрын шинж тэмдэг илрээгүй, оношлогоогүй байгаа зорилтот бүлгийнхнийг оношилгоо шинжилгээ(ЭХО үзлэг, цусанд АФП илрүүлэх шинжилгээ хийх болон бусад)-д хамруулж, элэгний хорт хавдрыг илрүүлэх, оношлох, бүртгэх, мэдээлэх, эрт хяналтад авч эмчлэх, оношийг баталгаажуулах, эргэн мэдээлэх, дараагийн шатанд шилжүүлэх, эрүүл бус зан үйлийг өөрчлөх зөвлөгөө мэдээллээр хангах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.2. Элэгний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийг “Элэг бүтэн Монгол” хөтөлбөртэй уялдуулан зохион байгуулах, бүртгэх, мэдээлэх, зөвлөмж гаргах, дүгнэлт өгөх, холбогдох байгууллагуудын уялдаа холбоог хангах, тулгамдсан асуудлыг тодорхойлж шийдвэрлэх үүрэг бүхий “Элэгний хорт хавдрын эрт илрүүлгийн баг” байгуулж ажиллана.

2.3. Элэгний хорт хавдрын эрт илрүүлэгт хамрагдах зорилтот бүлэг:

1/ HBsAg, Anti-HCV эерэг В,C вируст хепатитын халдварт тээгчид:

- хепатитын В,C вирусын халдварт тээгч гэдгээ өмнө нь мэддэг бүх насны хүмүүс;
- 40-65 насны HBsAg, Anti-HCV илрүүлэх шинжилгээнд хамрагдан хепатитын В,C вирус тээгч болох нь батлагдсан хүмүүс;
- 50-иас дээш насны, Anti-HCV эерэг С вируст хепатитын халдвартай, элэгний хатуурал хавсарсан хүмүүс;

2/ Элэгний архаг үрэвсэлтэй (ALAT 60-аас дээш), элэгний хатууралтай бүх насны хүмүүс;

3/ Элэгний анхдагч хорт хавдраар өвчлөгсдийн нэгдүгээр үеийн төрөл садан ба гэр булийн 40-өөс дээш насны хүмүүс.

2.4. Элэгний хорт хавдрын эрт илрүүлгээр өөрчлөлттэй илэрсэн хүнийг тусламж, үйлчилгээний шатлал хооронд илгээхдээ анхан шатны үзлэгийн үр дүнг тодорхой бичин 13-А маягтын баруун дээд өнцөтт “Эрт илрүүлэг” тэмдэглэгээг бичнэ.

2.5. Элэгний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийг хавсралтаар батлагдсан алгоритмын дагуу дараах байдлаар зохион байгуулна.

A.Өрх, сум / тосгоны/ эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн үүрэг:

- элэгний хорт хавдрыг эрт илрүүлэх үзлэг, шинжилгээний хуваарь, төлөвлөгөө хийж, зорилтот бүлгийн хүн амыг б сарын дотор үзлэгт бүрэн хамруулах;
- Үзлэгийн бүртгэлд тухайн үзлэгт хамрагдсан, дараагийн шатлалд шилжүүлж оношийг баталгаажуулсан, эмчилгээ хийлгэсэн, эрүүл мэндийн зөвлөгөөгөөр хангасан, эргэн дуудсан зэрэг асуудлыг тодорхой тусгасан байх;
- Үзлэгийн үр дүнг тооцон ажиллаж, зорилтот бүлгийн хүн амын бүртгэлийг б сар тутам шинэчилж байх;
- Нэгдсэн эмнэлгээс илрүүлэг үзлэгийн тухай мэдээллийг тогтмол авч, уялдаа холбоотой ажиллах.

Б. БОЭТ, Аймгийн Нэгдсэн эмнэлэг, дүүргийн Эрүүл мэндийн төвийн үүрэг:

- элэгний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэг, шинжилгээнд анхан шатны байгууллагаас илгээсэн хүнийг бүртгэж, үзлэг шинжилгээ хийх, оношийг баталгаажуулах, шаардлагатай тохиолдолд эмчилгээнд хамруулах, үр дүнг зорилтод бүлгийн хүнийг илгээсэн холбогдох байгууллага(анхан шатны байгууллага, ХСҮТ-д, хувийн хэвшлийн эмнэлэгт)-д эргэн мэдээлэх, бусад байгууллагатай хамтран ажиллах ажлын төлөвлөгөө боловсруулж ажиллах;
- эрт илрүүлэгт оролцох эмч нарыг багаар ажиллуулах;
- багийн бүрэлдэхүүнд дотрын эмч, хавдрын эмч, халдвартын эмч, хавдар бүртгэгч, клиник лабораторийн эмч, дүрс оношилгооны эмч зэрэг холбогдох эмч мэргэжилтнийг хамруулан эмч бүрийн чиг үүргийг тодорхойлон ажиллуулж, ажлын уялдааг хангах;
- хорт хавдрын сэжигтэй гарсан тохиолдлыг алгоритмын дагуу оношийг баталгаажуулах, хяналтад авах арга хэмжээ авах;
- Аймаг, дүүргийн түвшинд “Элэгний хорт хавдрын илрүүлэг” үзлэгээр элэгний хорт хавдар оношлогдсон тохиолдолд оношилсон эмч АМ-5 маягт хөтлөн харьяа орон нутгийн хавдар бүртгэгчид мэдээлнэ.
- аймаг, дүүргийн хавдар судлаач эмч алгоритмийн дагуу онош тодруулах шаардлагатай хүнийг Хавдар судлалын үндэсний төвд АМ-13А маягтаар илгээх.

**В. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар:**

- элэгний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэг, шинжилгээний чанар, хамралтыг нэмэгдүүлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах, хяналт тавих;
- эрт илрүүлгийн явц, оролцогч байгууллага бүрийн ажлын үр дүнг тооцох, уялдаа холбоог хангах уулзалтыг жил бүр зохион байгуулж, үр дүнг тооцох;
- аймаг, дүүргийн хэмжээний эрт илрүүлгийн мэдээг өрх, сум/тосгон/-ын эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв, бусад холбогдох эмнлэгээс авч нэгтгэн мэдээний сан үүсгэж, санг тухай бүр шинэчлэн, баяжуулах, дүнг ХСҮТ, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд хагас жил тутам илгээх;
- элэгний хорт хавдрын шалтгаантай тэмцэх, хүн амын эрүүл бус зан үйл, амьдралын хэв маягийг өөрчлөх цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
- эрт илрүүлгийн арга хэмжээнд шаардагдах тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулах, эмч мэргэжилтний тогтвортой ажиллах нөхцлийг бүрдүүлэх;
- эрт илрүүлгийн үзлэг, шинжилгээ, эмчилгээнд шаардагдах санхүүжилтийн тооцоо судалгааг гарган улс, орон нутгийн төсөвт тусгах, холбогдох бусад байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;
- эмч, мэргэжилтнүүдийг бэлтгэх, давтан сургах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах;
- илрүүлэг үзлэгт оролцох байгууллагуудын ажлын төлөвлөлт, үйл ажиллагааны уялдааг хангах;
- даатгуулагчид үзүүлэх даатгалын гэрээ байгуулсан, тусгай зөвшөөрөлтэй хувийн эрүүл мэндийн байгууллагуудын эрт илрүүлгийн үзлэгийн мэдээг авч нэгтгэх.

**Г. Хавдар судлалын үндэсний төв:**

- аймаг, дүүргээс элэгний хорт хавдрын сэжигтэй гэж тооцон илгээсэн иргэнийг нарийвчилсан оношилгоо, шинжилгээнд оруулж, оношийг баталгаажуулах, хавдрын өвөрмөц эмчилгээ хийх, эргэн мэдээлэх;
- мэргэжлийн эмч нарын багийг орон нутагт ажиллуулж, илрүүлгийн үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх хуваарь гарган ажиллах;
- эмч, эрүүл мэндийн мэргэжилтнүүдийг чадавхижуулах сургалтыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах;
- элэгний хорт хавдрын эрт илрүүлгийн алсын зайн сургалт явуулах, зөвлөгөө өгөх;
- эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран хийх.

### Хавдар судлалын үндэсний төвд:

1. ХСҮТ-ХБТЭИА нь аймаг, дүүргийн хавдар бүртгэгчийн нэгтгэж эрүүл мэндийн газрын статистикийн албаар хянуулсан элэгний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгийн мэдээг сар бүрийн 4-ны дотор цахим байдлаар хүлээж авна.

2. ХСҮТ-ийн ХБТЭИА нь элэгний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгийн сар, улирал, жилийн тайланг (Элэгний хорт хавдрын эрт илрүүлгийн тайлан) нэгтгэн жил бүрийн 2 дугаар сарын 15-ны дотор Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төвийн статистик мэдээлэл технологийн албандаа цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлнэ.

### Хоёр. Эргэн мэдээлэх

1. ХСҮТ-д онош тодруулахаар илгээсэн сэжигтэй тохиолдол нь хорт хавдар батлагдвал ХСҮТ-ХБТЭИА нь АМ-5 маягт болон цахим сангаар харьяа аймаг, дүүргийн хавдар бүртгэгчид мэдээлнэ.

2. Аймаг, дүүргийн эрүүл мэндийн газрын статистикийн алба, хавдар бүртгэгч, эрт илрүүлгийн багийн гишүүн нь элэгний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгийн мэдээг нэгтгэн, хянаж дүн шинжилгээ хийн, дараа сарын 5-ны дотор харьяа дүүрэг, өрх, суманд эргэн мэдээлнэ.

3. ХСҮТ-ХБТЭИА нь элэгний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгийн мэдээг нэгтгэн, мэдээний санд боловсруулалт, дүн шинжилгээ хийн холбогдох газруудад эргэн мэдээлнэ.


### Гурав. Элэгний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгт хэрэглэгдэх програм хангамж

Эрүүл мэндийн тогтолцоонд ашиглагдаж байгаа “elegbuten.mohs.mn”, “screening.gov.mn” програм хангамжуудыг ашиглана.

-оОо-

Эрүүл мэндийн сайдын  
2017 оны 11. сарын 28.-ны өдрийн  
A/547 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

## Элэгний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэг, оношилгоо, эмчилгээний алгоритм



Эрүүл мэндийн сайдын  
2017 оны 12. сарын 28.-ны өдрийн  
A/547 дугаар тушаалын 3 дугаар хавсралт

## Элэгний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийг бүртгэх, мэдээлэх журам

### Нэг. Элэгний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийг мэдээлэх

Өрх, сум /тосгоны/ эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн түвшинд:

1. "Элэгний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэг"-ийн зорилтот бүлгийн хүн амын бүртгэлийг сум (тосгон), өрхийн эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг нь "elegbuten.mohs.mn" програмд ЭИМ-8 дагуу оруулна.

2. Сум (тосгон), өрхийн эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн хариуцсан эмнэлгийн мэргэжилтэн нь элэгний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийн бүртгэлийг ЭМЯ-ны зөвшөөрсөн програмд мэдээллийг шивж оруулан сарын мэдээний нэгтгэлийн дагуу гаргаж, дараа сарын 1- ний дотор аймаг, дүүргийн хавдар бүртгэгчид мэдээлнэ.

БОЭТ, Аймгийн Нэгдсэн эмнэлэг, дүүргийн ЭМТ түвшинд:

1. Бүсийн оношилгоо, эмчилгээний төв /цаашид БОЭТ гэх/, аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төв, дүүргийн нэгдсэн эмнэлгийн эхо болон лабораторийн эмч, дотрын эмч, хавдар судлаач их эмч нар "screening.gov.mn" програмд ЭИМ-8 маягтын дагуу өгөгдлөө шивж оруулан мэдээний санг үүсгэнэ.

2. Аймаг, дүүргийн хавдар бүртгэгч нь элэгний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгийн мэдээг нэгтгэн, эрүүл мэндийн газрын мэдээллийн мэргэжилтнээр хянуулан, дараа сарын 4-ний дотор цахим хэлбэрээр Эрүүл мэндийн хөгжлийн төвийн статистик, мэдээллийн технологийн албанад, үүссэн мэдээний санг Хавдар судлалын үндэсний төвийн Хавдрын бүртгэл, тандалт эрт илрүүлгийн алба (цаашид ХСҮТ-ХБТЭИА гэх)-нд тус тус хүргүүлнэ. Сарын мэдээний нэгтгэлийн дагуу сар бүр тайлан гаргана.

3. Аймаг, дүүргийн түвшинд "Элэгний хорт хавдрын илрүүлэг" үзлэгээр элэгний хорт хавдар оношлогдсон тохиолдолд оношилсон эмч АМ-5 маягт хөтлөн харьяа орон нутгийн хавдар бүртгэгчид мэдээлнэ.

### Хавдар судлалын үндэсний төвд:

1. ХСҮТ-ХБТЭИА нь аймаг, дүүргийн хавдар бүртгэгчийн нэгтгэж эрүүл мэндийн газрын статистикийн албаар хянуулсан элэгний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгийн мэдээг сар бурийн 4-ны дотор цахим байдлаар хүлээж авна.
2. ХСҮТ-ийн ХБТЭИА нь элэгний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгийн сар, улирал, жилийн тайланг (Элэгний хорт хавдрын эрт илрүүлгийн тайлан) нэгтгэн жил бурийн 2 дугаар сарын 15-ны дотор Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төвийн статистик мэдээлэл технологийн албанд цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлнэ.

### Хоёр. Эргэн мэдээлэх

1. ХСҮТ-д онош тодруулахаар илгээсэн сэжигтэй тохиолдол нь хорт хавдар батлагдвал ХСҮТ-ХБТЭИА нь АМ-5 маягт болон цахим сангаар харьяа аймаг, дүүргийн хавдар бүртгэгчид мэдээлнэ.
2. Аймаг, дүүргийн эрүүл мэндийн газрын статистикийн алба, хавдар бүртгэгч, эрт илрүүлгийн багийн гишүүн нь элэгний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгийн мэдээг нэгтгэн, хянаж дүн шинжилгээ хийн, дараа сарын 5-ны дотор харьяа дүүрэг, өрх, суманд эргэн мэдээлнэ.
3. ХСҮТ-ХБТЭИА нь элэгний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгийн мэдээг нэгтгэн, мэдээний санд боловсруулалт, дүн шинжилгээ хийн холбогдох газруудад эргэн мэдээлнэ.

### Гурав. Элэгний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгт хэрэглэгдэх програм хангамж

Эрүүл мэндийн тогтолцоонд ашиглагдаж байгаа “elegbuten.mohs.mn”, “screening.gov.mn” програм хангамжуудыг ашиглана.

Эрүүл мэндийн сайдын

2017 оны 12. сарын 18.-ны өдрийн

А/547 дугаар тушаалын 4 дүгээр хавсралт

**Элэгний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийн сарын мэдээний нэгтгэл**

Аймаг, дүүргийн нэр.....

Ажлын утас.....


Эмнэлгийн нэр.....

Цахим шуудан.....

		Үзүүлэлт	м/ д	Тухайн сарын дүн	Оны эхнээс өссөн дүн
Өрх, сумын эмчийн илрүүлэг үзлэг	Аймаг, дүүргийн илрүүлэг үзлэг	Эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих хүний тоо (A)	1		
		Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан хүний тоо (B)=3+4+5+6+7+8+9+10+11	2		
		Үзлэгээр өөрчлөлтгүй эрүүл гарсан	3		
		40-65 насны HBsAg эерэг гарсан	4		
		40-65 насны Anti-HVC эерэг гарсан	5		
		Элэгний архаг үрэвсэлтэй( ALAT-60 дээш)	6		
		40-65 насны HBsAg + Anti-HVC эерэг гарсан	7		
		ЭАӨмөнгөөр өвчлөгсийн нэгдүгээр үеийн төрөл садан ба гэр бүлийн гишүүн 40 дээш насны хүмүүс	8		
		Жирэмсний хяналт	9		
		Цусны донор	10		
		Цэрэг татлага	11		
		AM-13A маягтаар илгээсэн хүний тоо	12		
		Өрх сумын эмчийн хяналтад орсон хүний тоо	13		
		Элэгний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийн хамралтын хувь=(B*100/A)	14		
		Үзлэгт хамрагдсан хүний тоо, бүгд=(15+16+17+18+19)	15		
	Эхо	Элгэнд 1 см дээш хэсэг газрын зангилаа илэрсэн хүний тоо	16		
		Элгэнд 1 см доош хэсэг газрын зангилаа илэрсэн хүний тоо	17		
		3 сарын дараах давтан үзлэгт зангилааны хэмжээ нь томорсон хүний тоо	18		
		Зангилааны хэмжээ 18-24 сарын туршид тогтвортой байгаа хүний тоо	19		

Лаборатори Үүнээс шинжилгээнд хамрагдсан хүнээс	Шинжилгээнд хамрагдсан хүний тоо	20		
	HBsAg зөрэг гарсан хүний тоо	21		
	HbeAg зөрэг гарсан хүний тоо	22		
	Anti-HCV зөрэг гарсан хүний тоо	23		
	Цусанд 10 ng/ml- эсвэл, 20 iu/ml-тэй тэнцүү, эсвэл бага гарсан хүний тоо	24		
	Цусанд 10 ng/ml-с эсвэл 20 iu /ml-с их гарсан хүний тоо	25		
	Цусанд дээрхи үзүүлэлтээс их гарсан хүний тоо	26		
	Аймаг, дүүргийн хяналтад шинээр авсан хүний тоо	27		
	Тухай аймаг дүүргээс АМ-13А маягтаар илгээсэн хүний тоо	28		

## Элэгний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэг, мэдээллийн урсгал




 Эрүүл мэндийн сайдын  
 2017 оны 12 сарын 28.-ны өдрийн  
 А/547 дугаар тушаалын 5 дугаар хавсралт

Эрүүл мэндийн бүртгэлийн маягт ЭИМ-8

ЭЛЭГНИЙ ХОРТ ХАВДРЫН ИЛРҮҮЛГИЙН МЭДЭЭЛЭХ ХУУДАС

Эмнэлгийн нэр: .....	РД.....	ЭМД-ын дугаар
1. Эцэг, эхийн нэр:.....	2. Өөрийн нэр: .....	
3. Төрсөн он сар өдөр / / 4. Нас [ ] 5. Хүйс: <input type="checkbox"/> Эрэгтэй <input type="checkbox"/> Эмэгтэй	6. Үндсэн захиргаа: Аймаг/ хот..... Сум/дүүрэг..... Баг, хороо.....	7.1 Холбоо барих утасны дугаар ..... 7.2. Цахим хаяг:.....
Эрт илрүүлэг үзлэгт орсон : ..... он ..... сар..... өдөр		
8. Илрүүлэг үзлэгт: <input type="checkbox"/> Θөх, сум, аймаг дүүргийн эмнэлгээс явуулсны дагуу хамрагдаж байгаа <input type="checkbox"/> Эмнэлэгт өөр шалтгаанаар хандах үедээ хамрагдаж байгаа Өөрийн хүснэгтээр: <input type="checkbox"/> Цахим хаягаар <input type="checkbox"/> Утасны SMS <input type="checkbox"/> Шуудангаар	9. Зорилтот бүлэг: <input type="checkbox"/> HBsAg, Anti-HCV эзрэг В, С вируст гепатитын халдварт тээгч <input type="checkbox"/> Элэгний архаг үрэвсэлтэй (ALAT60-аас дээш), элэгний хатууралтай <input type="checkbox"/> ЭАӨмнөгөөр өвчлөгсдийн нэгдүгээр үеийн төрөл садан ба гэр булийн 40-өөс дээш насны хүн <input type="checkbox"/> Цэрэг татлага <input type="checkbox"/> Жирэмсэн <input type="checkbox"/> Донор	
10. Элэгний В, С вирус хурдавчилсан сорил ..... он ..... сар..... өдөр	<input type="checkbox"/> HbsAg (+) эзрэг <input type="checkbox"/> Anti-HCV (+) эзрэг <input type="checkbox"/> HbsAg (-) сөрөг <input type="checkbox"/> Anti-HCV(-) сөрөг	
11. ELISA аргаар HBV/HCV (+) эзрэг гарсныг баталсан ..... он ..... сар..... өдөр	<input type="checkbox"/> HbsAg (+) эзрэг, титрийн хэмжээ ..... <input type="checkbox"/> HbeAg (+) эзрэг, титрийн хэмжээ ..... <input type="checkbox"/> Anti-HCV (+) эзрэг, титрийн хэмжээ.....	
12. Элэгний хавдрын маркер (альфафетопротеин) АФП(ng/ml) цусанд ..... он ..... сар..... өдөр	<input type="checkbox"/> 10 ng/ml- эсвэл, 20 iu/ml-тэй тэнцүү, эсвэл бага <input type="checkbox"/> 10 ng/ml-с эсвэл 20 iu /ml-с их <input type="checkbox"/> Дээрхи үзүүлэлтээс их	
13. Элэгний ЭХО шинжилгээ: ..... он ..... сар..... өдөр	<input type="checkbox"/> Хэвийн <input type="checkbox"/> Элэгний хэсэг газрын зангилаа (+) илэрсэн, Зангилаа нь 1 см-ээс бага хэмжээтэй <input type="checkbox"/> Зангилаа нь 1 см-ээс их хэмжээтэй <input type="checkbox"/> Нэг тооны <input type="checkbox"/> Олон тооны	
14. Чайлд-Пью үнэлгээ: ..... он ..... сар..... өдөр	<input type="checkbox"/> A 5-6 оноо <input type="checkbox"/> B 7-9 оноо <input type="checkbox"/> C 10-15 оноо	
15. Гурван фазтай КТГ шинжилгээ: ..... он ..... сар..... өдөр	<input type="checkbox"/> Хавдар бүхий илэрхий өөрчлөлтгүй <input type="checkbox"/> Хоргуй хавдар бүхий өөрчлөлттэй <input type="checkbox"/> Хортой, хоргуй нь тодорхойгүй <input type="checkbox"/> Хавдар бүхий өөрчлөлттэй	
16. Үндсэн онош: ..... ( Код:ӨОУА-10).....		

17. Авсан арга хэмжээ:	17.1   Өрх, сумын түвшинд: ..... он ..... сар..... өдөр		
	<input type="checkbox"/> Хяналтад авсан		
	17.2   Аймаг, дүүргийн түвшинд: ..... он ..... сар..... өдөр		
<input type="checkbox"/> Элэгний вирусын эмчилгээнд орохыг зөвлөсөн ( Илгээсэн эмнэлгийн нэр бичих.....)			
<input type="checkbox"/> Аймаг/дүүргийн эмнэлэг хяналтанд авсан			
<input type="checkbox"/> XCYT-рүү онош баталгаажулахаар илгээсэн			
17.3   XCYT болон бусад: ..... он ..... сар..... өдөр			
<input type="checkbox"/> Элэгний хорт хавдар оношлогдсон			
<input type="checkbox"/> Хавдрын өвөрмөц эмчилгээнд орсон			
<input type="checkbox"/> Харьяа аймаг, дүүргийн хяналтад илгээсэн			
<b>Мэдээлсэн эмчийн нэр:</b>			
Тамга	<b>Албан тушаал:</b>	<b>Утасны дугаар:</b>	<b>Гарын үсэг:</b>

**Эрт илрүүлгийн дүнг дараах зааврыг мөрдлөг болгон програмд “[www.screening.gov.mn](http://www.screening.gov.mn)” хаягаар нэвтрэн мэдээллийг оруулна:**

1. Энэхүү маят нь үйлчлүүлэгчийг шатлал хооронд шилжүүлэхэд 13А маягтын хамт дагалдана.
2. Өрх сумын эрүүл мэндийн төв 1-10, 17.1 дугаар асуумж хөтлөгдөн зохих програмд өгөгдлийг шивж оруулна.
3. Алгоритмын дагуу 11-17.2,3 дугаар асуумжийг холбогдох эмч нар хөтөлж програмд өгөгдлийг шивж оруулна.

Эрүүл мэндийн сайдын  
2017 оны 12. сарын 28.-ны өдрийн  
A/547 дугаар тушаалын б дугаар хавсралт

**Элэгний хатуурлын хүндрэлийн зэргийг тодорхойлох  
Чайлд-Пью шалгуурыг ашиглах заавар**

Элэгний хатуурлын хүндрэлийн зэргийг Чайлд-Пью шалгуураар тодорхойлно.

Чайлд-Пью шалгуураар нь элэгний циррозын хүндрэлийн зэргийг тодорхойлох зорилгоор ашиглагддаг бөгөөд дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Элэгний үйл ажиллагааг үнэлэхэд сийвэнгийн альбуимины хэмжээ болон протромбины хугацаа хамгийн сайн мэдээлэл өгнө. Хэрэв альбуимины хэмжээ 28 г/л-ээс буурсан тохиолдолд тавилан мууг илэрхийлнэ.
- Элэгний биохимиин үзүүлэлт нь элэгний хүндрэлийн зэргээс хамаарч өөрчлөлтэй гарч болно. Ихэнх тохиолдолд трансаминазууд болон шүлтлэг фосфатаза бага боловч ихэссэн байдаг. Ээнэгшил алдагдсан элэгний хатуурлын үед биохимиийн үзүүлэлтүүд нийтдээ өөрчлөгддөг.
- Сийвэнгийн электролитийн хэмжээнд нНатрийн хэмжээ багасах нь хүнд явцтай хатуурлын үед бие махбодын усыг ялгаруулах чадвар алдагдсан эсвэл шээс хөхөн эмчилгээ хүчтэй хийж байгааг илтгэнэ.

Элэгний хатуурлын тавилан болон хүнд, хөнгөн зэргийг тогтооход Чайлд-Пью шалгуурын 5 үзүүлэлт болгонд 1-3 оноо өгөн нийлбэрийг гаргана.

**Элэгний хатуурлын үеийн хүнд, хөнгөний зэрэглэл дүгнэх үнэлгээ  
(Чайлд-Пью)**

	Оноо		
	1 оноо	2 оноо	3 оноо
Альбумин	>35 г/л	28-35 г/л	<28 г/л
Билирубин	<2.0 мг/дл <34 ммоль/дл	2-3 мг/дл (34-50 ммоль/л)	2-3 мг/дл (34-50 ммоль/л)
Протромбины хугацаа (INR)	1-3 секунд удааширсан <1.7	2-6 секунд удааширсан <1.71-2.20	6 секунд удааширсан >2.3
Асцит	Байхгүй	Эмийн эмчмлгээний үр дүн сайн	Эмийн эмчмлгээний үр дүн муу эсвэл рефрактори асцит
Энцефалопати	Байхгүй	I-II	II-III

**Элэгний хатуурлын үеийн Чайлд-Пью зэргээр тавиланг тодорхойлох**

Оноо	Зэрэг	1 жил амьдрах магадлал	2 жил амьдрах магадлал
5-6	A	100%	85%
7-9	B	81%	57%
10-15	C	45%	35%

Эрүүл мэндийн сайдын  
2017 оны 12. сарын 28. ны өдрийн  
1547 дугаар тушаалын 7 дугаар хавсралт

Элэгний хорт хавдрын эрт илрүүлэгт шаардагдах оношлуур, багаж хэрэгсэл, тонон төхөөрөмжийн жагсаалт

	Тонон төхөөрөмжийн жагсаалт	ХСҮТ	БОЭТ	Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг	Дүүргийн эрүүл мэндийн төв	Өрх/сум/тосгоны эрүүл мэндийн төв
1.	HBsAg , anti-BeAg илрүүлэх хурдавчилсан тест				+	+
2.	Биохимиин шинжилгээний урвалж	+	+	+	+	
3.	Дижитал эхо аппарат		+	+	+	
4.	ELISA машин (Альфафетопротейн маркер, биохими, антиген, В, С вирус тоолох)		+	+	+	
5.	Фиброскан	+	+	+		
6.	Цахилгаан соронзон томографи (MRI 1,5 TC)	+				
7.	Компьютер томографи (64 өөс дээш зүслэгтэй)	+				
8.	PCR машин	+	+			
9.	HISCL - 5000 (Элэгний цирроз, гормон, В, С вирус үздэг, биохимийн шинжилгээ хийдэг)	+	+			
10.	Ангиографийн рентген харалттай аппаратын иж бурдэл	+				

Эрүүл мэндийн сайдын  
2017 оны 12. сарын 28.-ны өдрийн  
А/БЧ дугаар тушаалын 8 дугаар хавсралт

### **Элэгний хорт хавдрын эрт илрүүлгийн шалгуур үзүүлэлт**

Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар элэгний хорт хавдрын эрт илрүүлэгт оролцож байгаа байгууллага тус бүрээр дараах шалгуур үзүүлэлтийн суурь түвшин, мэдээлэх тогтолцоог бүрдүүлэн жил бүрийн хагас, бүтэн жилээр гарган Хавдар судлалын үндэсний төвд мэдээлнэ.

	Үзүүлэлт	Хагас жилд	Бүтэн жилд
<b>I. Өрх, сумын эмнэлгийн түвшинд гаргах шалгуур үзүүлэлт:</b>			
1	HBsAg , anti-BeAg илрүүлэх хурдавчилсан тестэд хамрагдсан хүн ам /хувиар/	+	+
2	Элэгний хорт хавдрын эрт илрүүлгийн хамрагдалтын хувь	+	+
3	Өрх сумын эмчийн хяналтад авсан хүний эзлэх хувь	+	+
4	Хяналтад байгаа үйлчлүүлэгчдээс 6 сар тутамд давтан үзүүлж буй хүний эзлэх хувь	+	+
<b>II. Аймаг, дүүргийн түвшинд гаргах шалгуур үзүүлэлт:</b>			
1	Анхан шатны байгууллагаас элэгний хорт хавдрын эрт илрүүлгийн оношийг баталгаажуулахаар илгээсэн хүний тоо	+	+
2	Тухайн жилд элэгний хатууралтай гэж шинээр оношилогдсон хүний эзлэх хувь	+	+
3	Аймаг, дүүргүүд ХСҮТ-д АМ-13А-аар онош тодруулахаар илгээсэн хүний эзлэх хувь	+	+
4	Элэгний эрт илрүүлгийн үзлэгт оролцож байгаа хувийн эмнэлэг, лабораторийн тоо	+	+
<b>III. Хавдар судлалын үндэсний төв:</b>			
1	Аймаг, дүүргээс ХСҮТ-д илгээгдэж онош баталгаажуулагдсан үйлчлүүлэгчийн тоо	+	+
2	ХСҮТ-д аймаг, дүүргээс илгээсэн үйлчлүүлэгчийн эмчилгээнд хамрагдсан хүний тоо	+	+
3	Элэг шилжүүлэн суулгах мэс засалд хамрагдсан үйлчлүүлэгчийн эзлэх хувь	+	+
<b>IV. Нийтлэг шалгуур үзүүлэлт:</b>			
1	Элэгний хорт хавдрын эрт илрүүлгийн чиглэлээр бэлтгэгдсэн эмч, мэргэжилтний тоо		+
2	Шинээр аппарат, тоног төхөөрөмжөөр хангагдсан аймаг, дүүргийн тоо		+
3	Элэгний хорт хавдрын эрт үедээ илэрсэн хувь		+
4	Элэгний хорт хавдрын 5 ба түүнээс дээш жилдээ амьдарсан хүний эзлэх хувь		+
5	Эрт илрүүлгийн үйл ажиллагаанд дотоодын хяналт үнэлгээ хийгдсэн тоо		+
6	Бусад эх үүсгэвэрээр элэгний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийн үйл ажиллагаанд зарцуулсан санхүүжилт, мөнгөн дүнгээр †		+